



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулах зөвлөл байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.1, 18.5 дахь заалт, Засгийн Газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны А/131 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Залуучуудын Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгон шалгаруулах зөвлөлийг байгуулсугай.

2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Залуучуудын Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгон шалгаруулах зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Үндэсний шигшээ багийн алба /Ч.Насантогтох/-нд даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Одонбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

000000138

Биеийн тамир, спортын газрын даргын 2017 оны 02 сарын
24-ны өдрийн 7/ дугаар тушаалын хавсралт
53



**ЗАЛУУЧУУДЫН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙГ БҮРДҮҮЛЭХ СПОРТЫН ТӨРЛИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн
хэлтсийн дарга

Гишүүд:

Үндэсний шигшээ багийн албаны дарга

Спортын бодлогын хэрэгжилтийн
зохицуулалтын хэлтсийн дарга

Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээ
судалгааны албаны дарга

Үндэсний шигшээ багийн албаны өндөр
зэрэглэлтэй тамирчдын сургалт
дасгалжуулалтын төлөвлөлт хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичиг:

Үндэсний шигшээ багийн албаны өсвөр үе,
залуучуудын шигшээ багийн асуудал
хариуцсан мэргэжилтэн